

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/571/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас:70007734 Цахим хаяг:boldch@audit.gov.mn</p> <p>Хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 261628 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч Ниямазон аудит ХХК, захирал З.Цээнэ Утас: 99135906 Цахим хаяг: audit@nmz.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025. 02. 05 № 01/242
танай _____-ны № _____-т

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.НАРАНБААТАР
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,201,793.6 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Иргэний хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нийцээгүй, санхүүгийн тайлагналын "Эрх ба үүрэг", "Тохиолдсон байх", "Оршин байх", "Толилуулга", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт дутуу олгогдсонтой холбоотой байгууллагын өр төлбөр 1,340,573.5 мянган төгрөгөөр нэмэгджээ.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Төрийн аудитын байгууллагад 2024 оны санхүүгийн тайлан, холбогдох баримт, материалыг хуульд заасан хугацаанд ирүүлээгүй нь аудит хийх цаг хугацааны хязгаарлагдмал байдал үүсгэсэн.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 80 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг 96.5 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	934,618,795.35	3,068,041,815.81
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,224,600.00	384,112,767.84
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	7,224,600.00	384,112,767.84
3121	Төгрөг	7,224,600.00	384,112,767.84
31211	Төрийн сангийн харилцах	7,224,600.00	384,112,767.84
33	АВЛАГА	139,195,366.67	1,563,063,205.62
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	27,791.37	307,517.02
33300	Татаас, санхүүжилтийн авлага	114,257,205.00	1,531,907,979.30
335	Бусад авлага	24,910,370.30	30,847,709.30
3351	Байгууллагаас авах авлага	24,910,370.30	30,847,709.30
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	788,198,828.68	1,120,865,842.35
351	Түүхий эд материал	487,368,050.95	641,368,271.67
35110	Тусгай зориулалттай материал	41,594,399.76	41,693,659.00
35130	Эм боох материал	445,773,651.19	599,674,612.67
354	Хангамжийн материал	300,830,777.73	479,497,570.68
35410	Бичиг хэргийн материал	12,353,475.00	21,790,270.00
35420	Аж ахуйн материал	79,110,735.00	108,833,583.85
35430	Сэлбэг хэрэгсэл	3,425,000.00	17,801,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,429,864.06	11,576,761.16
35470	Бусад хангамжийн материал	203,511,703.67	319,495,955.67
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,021,447,942.23	10,054,675,480.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,021,447,942.23	10,054,675,480.26
392	Биет хөрөнгө	8,803,769,222.23	9,836,996,760.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,876,132,031.40	7,061,332,031.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	(885,861,630.00)	(1,232,213,724.40)
39203	Авто тээврийн хэрэгсэл	240,536,081.90	240,536,081.90
39204	Хуримтлагдсан элэгдэл	(155,796,559.34)	(171,337,061.78)
39205	Машин тоног төхөөрөмж	6,754,257,650.62	6,852,867,421.02
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,187,546,214.64)	(3,109,126,247.48)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	333,438,925.66	311,485,715.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(171,391,063.37)	(116,547,455.40)
393	Биет бус хөрөнгө	217,678,720.00	217,678,720.00
39301	Програм хангамж	9,959,570.00	9,959,570.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(9,959,570.00)	(9,959,570.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	217,678,720.00	217,678,720.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,956,066,737.58	13,122,717,296.07
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,423,006,919.76	2,763,580,419.65
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,423,006,919.76	2,763,580,419.65
413	Өглөг	1,423,006,919.76	2,763,580,419.65
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	200,980,126.90	325,705,093.39
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,204,739,392.86	2,434,007,576.26
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	-	-
4136	Бусад өглөг	17,287,400.00	3,867,750.00
41361	Байгууллагад төлөх өглөг	17,287,400.00	3,782,700.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	85,050.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,533,059,817.82	10,359,136,876.42

**Нийслэлийн Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

51	Засгийн газрын хувь оролцоо	<u>8,533,059,817.82</u>	<u>10,359,136,876.42</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	2,690,475,497.94	2,690,475,497.94
51101	Өмч: - төрийн	2,690,475,497.94	2,690,475,497.94
512	Хуримтлагдсан үр дүн	<u>2,696,528,156.67</u>	<u>4,522,605,215.27</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	4,742,151,050.25	2,697,477,904.86
51220	Тайлант үеийн үр дүн	(2,045,622,893.58)	1,825,127,310.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,146,056,163.21	3,146,056,163.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>9,956,066,737.58</u>	<u>13,122,717,296.07</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	15,825,383,549.26	18,153,048,684.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,074,478,771.26	5,328,560,902.36
120	Нийтлэг татварын бус орлого	5,074,478,771.26	5,328,560,902.36
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,420,802,328.00	1,730,804,072.02
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,405,610,428.00	1,285,765,610.02
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,191,900.00	445,038,462.00
120005	Түрээсийн орлого	-	844,800.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	2,071,810,909.18	1,888,116,702.30
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	1,581,865,534.08	1,708,795,328.04
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,750,904,778.00	12,824,487,782.60
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	282,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	282,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,750,904,778.00	12,542,487,782.60
134002	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	10,750,904,778.00	12,542,487,782.60
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	16,919,361,704.06	16,327,921,374.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,849,043,233.56	15,943,107,225.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,849,043,233.56	15,943,107,225.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,012,995,139.54	7,343,597,916.52
210101	Үндсэн цалин	3,256,298,722.92	4,107,494,549.26
210102	Нэмэгдэл	1,895,144,629.48	1,925,517,475.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	366,869,000.00	588,355,000.00
210104	Урамшуулал	494,682,787.14	722,230,892.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	747,281,273.89	888,156,308.35
210201	Тэтгэврийн даатгал	525,018,562.85	615,452,951.48
210202	Тэтгэмжийн даатгал	61,961,371.21	74,122,297.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	48,218,296.85	47,716,351.22
210204	Ажилгүйдлийн даатгал	10,060,299.60	29,792,178.39
210205	Эрүүл мэндийн даатгал	102,022,743.38	121,072,530.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	177,571,936.43	204,367,323.03
210301	Гэрэл, цахилгаан	70,743,961.28	93,927,500.76
210302	Түлш, халаалт	34,587,515.69	77,448,034.97
210303	Цэвэр, бохир ус	72,240,459.46	77,448,034.97
2104	Хангамж, бараа материалын зардал	631,570,002.56	230,760,980.56
210401	Бичиг хэрэг	53,843,945.00	34,676,055.00
210402	Тээвэр, шатахуун	24,019,178.84	9,686,702.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,306,201.41	12,223,011.90

**Нийслэлийн Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	20,282,000.00	16,821,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,648,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	374,680,706.69	155,705,210.76
210408	Бараа материал акталсны зардал	141,437,970.62	-
2105	Нормативт зардал	7,370,571,840.28	5,987,764,654.51
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,086,165,840.28	5,793,481,660.51
210502	Хоол, хүнс	284,406,000.00	194,282,994.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,507,150.00	37,642,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,400,000.00	-
210604	Урсгал засвар	47,107,150.00	37,642,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,052,912,170.78	234,781,858.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,043,544,250.78	226,530,858.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,176,000.00	8,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	339,120.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	434,800.00	206,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	45,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	264,000.00	-
210807	Газрын төлбөр	55,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	800,633,720.08	1,016,036,184.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	476,000.00	4,654,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	522,843.00	21,362,810.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	799,634,877.08	990,019,374.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,318,470.50	384,814,149.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,318,470.50	307,181,472.34
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	296,880,773.34
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	70,318,470.50	10,300,699.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	77,632,676.97
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	77,632,676.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(1,093,978,154.80)</u>	<u>1,825,127,310.41</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	951,644,738.78	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	951,644,738.78	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(951,644,738.78)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(2,045,622,893.58)</u>	<u>1,825,127,310.41</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	12,043,077,675.00	13,188,560,074.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,406,430,102.00	1,781,723,074.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,406,430,102.00	1,781,723,074.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,406,430,102.00	1,781,723,074.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,391,238,202.00	1,338,519,828.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,191,900.00	442,358,446.00
120005	Түрээсийн орлого	-	844,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,636,647,573.00	11,406,837,000.30
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	282,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	282,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,636,647,573.00	11,124,837,000.30
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	799,460,739.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	10,636,647,573.00	10,325,376,261.30
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	12,408,151,377.31	12,676,541,696.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,408,151,377.31	12,676,541,696.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,337,832,906.81	12,291,727,547.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,890,553,909.05	7,136,825,305.48
210101	Үндсэн цалин	3,132,667,303.73	3,694,647,937.23
210102	Нэмэгдэл	1,885,322,621.74	2,116,328,921.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	367,196,896.98	582,706,868.66
210104	Урамшуулал	505,367,086.60	743,141,577.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	668,742,377.48	968,985,411.34
210201	Тэтгэврийн даатгал	454,744,816.69	713,224,185.29
210202	Тэтгэмжийн даатгал	53,499,390.18	64,762,756.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	42,799,509.19	44,197,541.69
210204	Ажилгүйдлийн даатгал	10,699,878.05	19,367,557.81
210205	Эрүүл мэндийн даатгал	106,998,783.37	127,433,369.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	177,542,491.63	204,367,323.03
210301	Гэрэл, цахилгаан	70,743,961.28	93,927,500.76
210302	Түлш, халаалт	34,558,070.89	32,991,787.30
210303	Цэвэр, бохир ус	72,240,459.46	77,448,034.97
2104	Хангамж, бараа материалын зардал	183,135,271.71	226,230,089.90
210401	Бичиг хэрэг	15,363,700.00	42,050,478.00
210402	Тээвэр, шатахуун	20,735,000.00	18,833,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,736,571.71	12,223,011.90
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	29,300,000.00	23,888,000.00

**Нийслэлийн Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	100,000,000.00	129,235,000.00
2105	Нормативт зардал	4,159,608,485.48	3,334,392,791.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,875,202,485.48	3,067,182,791.40
210502	Хоол, хүнс	284,406,000.00	194,177,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	73,033,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	121,880,706.00	125,709,818.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,442,500.00	26,177,700.00
210602	Тавилга	6,240,000.00	-
210604	Урсгал засвар	100,198,206.00	99,532,118.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,100,129,510.96	244,915,258.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,059,931,190.96	221,516,858.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,176,000.00	8,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	339,120.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	434,800.00	206,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	45,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,215,910.00	6,614,400.00
210807	Газрын төлбөр	55,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	17,878,490.00	8,533,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,240,154.50	50,301,550.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,766,971.50	28,768,740.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,473,183.00	21,532,810.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,318,470.50	384,814,149.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,318,470.50	307,181,472.34
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	296,880,773.34
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	70,318,470.50	10,300,699.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	199,874,441.14	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	194,020,725.16	-
213305	Үндсэн үйл ажиллаган орлого	5,853,715.98	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	77,632,676.97
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	77,632,676.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(365,073,702.31)	507,128,377.84
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	58,558,620.00	135,130,210.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	58,558,620.00	135,130,210.00
2200	Дотоод эх үүсвэрээр	58,558,620.00	135,130,210.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	58,558,620.00	135,130,210.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(58,558,620.00)	(135,130,210.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(423,632,322.31)	376,888,167.84
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	430,856,922.31	7,224,600.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,224,600.00	384,112,767.84

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	2,690,475,497.94	4,153,516,513.54	3,682,879,196.49	10,526,871,207.97
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		51,811,503.43	51,811,503.43
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,690,475,497.94	4,153,516,513.54	3,734,690,699.92	10,578,682,711.40
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			1,007,459,509.68	1,007,459,509.68
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	(1,007,459,509.68)	-	(1,007,459,509.68)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,045,622,893.58)	(2,045,622,893.58)
C08	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2,690,475,497.94	3,146,057,003.86	2,696,527,316.02	8,533,059,817.82
D01	2024 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	2,690,475,497.94	3,146,057,003.86	2,696,527,316.02	8,533,059,817.82
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			949,748.19	949,748.19
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,690,475,497.94	3,146,057,003.86	2,697,477,064.21	8,534,009,566.01
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,825,127,310.41	1,825,127,310.41
D09	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2,690,475,497.94	3,146,057,003.86	4,522,604,374.62	10,359,136,876.42

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,301,758,400.00	12,734,039,229.49	1,567,719,170.51	89.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,301,758,400.00	12,734,039,229.49	1,567,719,170.51	89.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,989,958,600.00	12,426,857,757.15	1,563,100,842.85	88.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,930,322,600.00	7,136,825,305.48	793,497,294.52	90.0
210101	Үндсэн цалин	3,549,682,000.00	3,694,647,937.23	(144,965,937.23)	104.1
210102	Нэмэгдэл	3,217,244,200.00	2,116,328,921.83	1,100,915,278.17	65.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	519,256,900.00	582,706,868.66	(63,449,968.66)	112.2
210104	Урамшуулал	644,139,500.00	743,141,577.76	(99,002,077.76)	115.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	973,876,700.00	968,985,411.34	4,891,288.66	99.5
210201	Тэтгэврийн даатгал	755,124,500.00	713,224,185.29	41,900,314.71	94.5
210202	Тэтгэмжийн даатгал	54,688,100.00	64,762,756.89	(10,074,656.89)	118.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	27,344,000.00	44,197,541.69	(16,853,541.69)	161.6
210204	Ажилгүйдлийн даатгал	27,344,000.00	19,367,557.81	7,976,442.19	70.8
210205	Эрүүл мэндийн даатгал	109,376,100.00	127,433,369.66	(18,057,269.66)	116.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	282,000,000.00	204,367,323.03	77,632,676.97	72.5
210301	Гэрэл, цахилгаан	116,000,000.00	93,927,500.76	22,072,499.24	81.0
210302	Түлш, халаалт	71,000,000.00	32,991,787.30	38,008,212.70	46.5
210303	Цэвэр, бохир ус	95,000,000.00	77,448,034.97	17,551,965.03	81.5
2104	Хангамж, бараа материалын зардал	234,135,600.00	226,230,089.90	7,905,510.10	96.6
210401	Бичиг хэрэг	47,969,000.00	42,050,478.00	5,918,522.00	87.7
210402	Тээвэр, шатахуун	18,833,600.00	18,833,600.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,000,000.00	12,223,011.90	1,776,988.10	87.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	23,333,000.00	23,888,000.00	(555,000.00)	102.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	130,000,000.00	129,235,000.00	765,000.00	99.4
2105	Нормативт зардал	3,904,930,100.00	3,334,392,791.40	570,537,308.60	85.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,592,489,400.00	3,067,182,791.40	525,306,608.60	85.4
210502	Хоол, хүнс	221,753,100.00	194,177,000.00	27,576,100.00	87.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	90,687,600.00	73,033,000.00	17,654,600.00	80.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,464,300.00	260,840,028.00	39,624,272.00	86.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	178,469,900.00	143,631,910.00	34,837,990.00	80.5
210602	Тавилга	-	12,786,000.00	(12,786,000.00)	
210604	Урсгал засвар	121,994,400.00	104,422,118.00	17,572,282.00	85.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	295,379,300.00	244,915,258.00	50,464,042.00	82.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	259,301,800.00	221,516,858.00	37,784,942.00	85.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,281,300.00	8,000,000.00	2,281,300.00	77.8

**Нийслэлийн Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210803	Даатгалын үйлчилгээ	534,600.00	-	534,600.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	596,700.00	206,000.00	390,700.00	34.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000.00	45,000.00	205,000.00	18.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,833,000.00	6,614,400.00	5,218,600.00	55.9
210807	Газрын төлбөр	3,456,900.00	-	3,456,900.00	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,125,000.00	8,533,000.00	592,000.00	93.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,850,000.00	50,301,550.00	18,548,450.00	73.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,500,000.00	28,768,740.00	3,731,260.00	88.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	36,350,000.00	21,532,810.00	14,817,190.00	59.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	311,799,800.00	307,181,472.34	4,618,327.66	98.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	311,799,800.00	307,181,472.34	4,618,327.66	98.5
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	296,899,800.00	296,880,773.34	19,026.66	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,900,000.00	10,300,699.00	4,599,301.00	69.1
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,301,758,400.00	13,110,927,431.33	1,190,830,968.67	91.7
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	282,000,000.00	204,367,323.03	77,632,676.97	72.5
132001	Орон нутгийн төсвөөс	282,000,000.00	204,367,323.03	77,632,676.97	72.5
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11,956,977,300.00	11,124,837,008.30	832,140,291.70	93.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,956,977,300.00	11,124,837,008.30	832,140,291.70	93.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,062,781,100.00	1,781,723,100.00	281,058,000.00	86.4
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,378,998,200.00	1,339,364,654.00	39,633,546.00	97.1
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	676,558,300.00	442,358,446.00	234,199,854.00	65.4
1200043	Өмнөх оны үлдэгдлээс санхүүжих	7,224,600.00	7,224,600.00		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,224,600.00	7,224,600.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		384,112,767.84		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		-	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	224	212	12	94.6
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	204	192	12	94.1
620003	Үйлчлэх ажилтан	19	19	-	100.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 2,944,012.7 мянган төгрөгийн алдаа ¹ илэрч санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Аудитаар нийт 2,201,793.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 203,601.7 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,925,503.0 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 72,688.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар илрүүлсэн 2,201,793.6 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,023,083.6 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тусгай зөвшөөрөлгүй компаниас эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан	1	191,804.8	1	191,804.8	-	-	-	-	-	-	-	-
ISO 9001-2015 нэвтрүүлэхээр гэрээнд заасан ажлыг гүйцэтгээгүй	1	9,000.0	1	9,000.0	-	-	-	-	-	-	-	-
Хувь хүний орлогын албан татварыг ногдуулж төлөөгүй	1	2,796.9	1	2,796.9	-	-	-	-	-	-	-	-
Тооцооны үлдэгдлийг баталгаажуулаагүй маягт НХМ-Т 3 маягыг мөрдөөгүй	1	1,591,454.1	-	-	1	1,591,454.1	-	-	-	-	-	-
Ирсэн нэхэмжлэх, төлбөрийн баримтыг шийдвэрлээгүй, хууль зөрчсөн нэхэмжлэхийг буцаагаагүй	1	206,199.2	-	-	1	206,199.2	-	-	-	-	-	-
Анхан шатны баримтгүй төлбөр хийсэн	1	30,435.5	-	-	1	30,435.5	-	-	-	-	-	-
Түрээсийн гэрээг бичгээр байгуулаагүй	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй	1	97,414.2	-	-	1	97,414.2	-	-	-	-	-	-
Төлбөрийг өглөгийн дансаар дамжуулаагүй	1	72,688.9	-	-	-	-	1	72,688.9	-	-	-	-
Нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн хугацаанд төлөөгүй	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	10	2,201,793.6	3	203,601.7	5	1,925,503.0	2	72,688.9	-	-	-	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засварын гэрээ нь агуулгатайгаа нийцээгүй гэрээ байгуулсан	1	19,488.0	-	-	1	19,488.0		
Санхүүгийн баримт материалыг хуулийн хугацаанд ирүүлээгүй, аудитын хугацаанд нөлөөлсөн	1	-	-	-	1	-		
Дүн	2	19,488.0			2	19,488.0		